

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/343 захирамжийн дагуу сумын төсөвт байгууллагын үйл ажиллагаанд хийгдэх дотоод хяналт шалгалтын ажлыг 6 дугаар сарын 6-нд зохион байгууллаа. Сумын Засаг даргын 2022 оны А/48 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, тухайн салбарын чиглэлээр хамааралтай, бүртгэл, хяналтад байлгаж, биелэлт үр дүнг тооцох Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг хянах, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/237 тоот “Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай” захирамжийн дагуу хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж ажилласан. Тоологчоор 4 албан хаагч, шаллагчаар 1 албан хаагч ажиллаж, сумын хэмжээнд ХААТ-1а маягтаар буюу газар тариалан эрхэлдэг өрх -5, ХААТ-2 буюу хөдөө аж ахуйн маягтаар – 286 өрх, ХААТ-2б маягтаар 5 аж ахуйн нэгжийг тоолж, гаргасан зураглалын дагуу 10 хоногт багтаан тоолсон. Тооллогод 3190 км явж 1539.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг сумын Засаг даргын А/51 тоот захирамжийн дагаа ажлын хэсэг томилогдон, хөтөлбөр боловсруулан, хөтөлбөрийн хүрээнд “Тэр бөхийн нэр хэний хэн бэ” бөхийн барилдаан, хөгжөөнт буухиа, гүйлт, шагайн харваа, унадаг дугуй, шатар, гэр бүлээрээ зураг зурах зэрэг уралдаан тэмцээн зохион байгууллаа. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг сумын Засаг даргын А/56 захирамжаар Автомашингүй өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүллээ.

Сумын Засаг даргын 2022 оны А/62 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

06 дугаар сарын 20-ны өдрөөс 22-ны өдрүүдэд “Газар, дэлхий” ХХК-аас сумын газар зохион байгуулалт, бэлчээрийн ашиглалт, нөхөн сэргээлт, усны хамгаалалт бүхий газар, зэрлэг ан амьтны тархалт, мэрэгч амьтны тархалт, устгал хийх газруудыг тус бүрчлэн газрын зураг дээр тэмдэглэж аймгийн газар зохион

байгуулалтын хэтийн төлөвлөгөөнд тусгуулахаар ажилласан ба хүн амын өсөлт бууралт, боловсрол, ажиллах хүчний талаарх судалгааг нарийвчлан гаргалаа.

2022 оны 06 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3433, өрх 986, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. 6 дугаар сарын байдлаар шинээр төрсөн 7, нас барсан 12 хүн бүртгэгдсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар албан даалгаврын хүрээнд сар бүрийн 24-ний өдрийн дотор “Хариу арга хэмжээний тайлан”-г “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан тоотын дагуу эрсдэлт нөхцөлд амьдардаг 57 хүүхдийн эрсдэлийн үнэлгээг нэг бүрчлэн гаргаж тус байгууллагад 06 дугаар сарын 06-ны өдөр холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 0-97 настай хүмүүсийн судалгааг хүн амын тоо, насны бүлгийн байдлаар нас тус бүрээр нь тулгалт хийж аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ болох Оёдол, Модон эдлэл, Талх нарийн боов, Блок үйлдвэрлэлийн мэдээнүүдийг гарган Статистикийн хэлтэст хүргүүлсэн

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын 2022 оны төлөвлөгөөний дагуу 20,0 сая төгрөгний сумын наадмын талбайн засварын ажил хийгдэж байна. Мөн сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил шууд худалдан авах гэрээний дагуу хийгдэж эхлээд байна.

Сумын Засаг даргын 2022 оны А/54, А/55 тоот захирамжуудаар нийт 4 иргэнд 2797мкв газрын өмчлүүлэх ажил хийгдлээ. Сумын ИТХ-ын ээлжит 8 дугаар

хуралдаанаар сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотголоор 11 асуудлыг оруулж 9 асуудлыг батлуулсан.

Сумын хэмжээнд 2022 оны мал төллөлт 76,1%, төл бойжилт 100% байна. Том малын зүй бус хорогдолгүй байхгүй.

Түвшинширээ сумын мал сүрэгт зонхилон гардаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 төрлийн төлөвлөгөөт тарилга хийгдэхээс дотрын халдварт хордлого, шөвөг яр, боом, листериоз, галзуу зэрэг вакциныг татан авч аж ахуй нэгжүүдэд хуваарилан өгсөн. Тарилгыг ажлыг хийж гүйцэтгэн цахим системд оруулж, баталгаажуулалт хийж холбогдох материалыг мал эмнэлгийн газарт хүргүүллээ. Сумын хэмжээнд листериоз 2102, галзуу 351, боом 6195, дотрын халдварт хордлого 80233, бүгд 88881 толгой мал орон нутгийн төлөвлөгөөт тарилганд хамрагдсан байна. Сахуу, цусан халдвартын вакциныг татан авч төлөвлөгөөт айл өрхөд хийгдэхээр төлөвлөж байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтад сумаас 3 өрхийн 18 үхрээс цус авч хүргүүлэв.

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч малчидтай биеэр болон утсаар холбогдож уг өвчний талаар сэрэмжлүүлгийг өгч ажиллалаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгч 8, шинэ ажлын байр-20 иргэн, түр ажлын зуучлал-21 нийт 49 иргэний мэдээллийг бүртгэсэн.

2022 оны 06-р сард 2020-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 9 иргэн хуваарийн дагуу 1762500 төвлөрүүлэхээс 8 иргэн 1462500 төгрөгийн ХЭДС-ийн дансанд төвлөрүүлсэн.

"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд малжуулах арга хэмжээний төслийг сумын хэмжээнд зарласан нийт 7 төслөөс 6 төслийг сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн сонгон шалгаруулсан. Нийт 6 өрхөд 30 сая төгрөгийн мал худалдан авах төсөл болон холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймгийн ХХҮГ-т хүргүүлсэн ба энэ сардаа багтаан хүлээлцэхээр ажиллаж байна.

"Ажил хайгч залуучууд ажлын дадал, туршлага эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэх " 2 цагийн сургалтад 4 иргэн хамруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т дэмжигдсэн 2 иргэний "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т 1 иргэн иргэн, нийт 3 иргэнд 21 сая төгрөгийн төсөл дэмжигдсэн ба гэрээ, батлан даагчийн гэрээ,эргэн төлөлтийн хувиар зэрэг холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ХХҮГ-т хүргүүлсэн.

ХХҮГ, сумын ЗДТГ-тай хамтран "Хашаа татах, нүх ухах" нийтийг хамарсан ажлыг 2022-05-23 ны өдрөөс 2022-06-06 ны хугацаанд ажлын 10 хоног 10 иргэн ажиллууллаа. Мөн "Ногоон ажлын байр" хөтөлбөрийн хүрээнд ХХҮГ, сумын ЗДТГ хамтран мод тарих, арчлах хамгаалах ажлыг 2022 оны 06-р сарын 07-ны өдрөөс эхлэн 10 хоногт 15 иргэн хамрагдсан. Нийт давхардсан тоогоор 21өрхийн 25 иргэнд хамрагдаж түр ажлын байраар зуучилсан.

Оролцоо төслийн бүртгэлд хамрагдах хүсэлтэй 18-34 насны залуучуудад зарыг өгч нийт 7 иргэн Emongolia.mnd бүртгэсэн. Бүртгэсэн залуучуудаас 5 иргэн ярилцлагын шалгалтанд хамрагдаад байна.

Алдарт эхийн 2-р одонгийн болзол хангасан 13 иргэний мэдээллийг ехаламж программд бүртгэн 1300,0 төгрөгийн мөнгөн тэтгэмжид хамруулсан.

Улсын баяр наадмыг тохиолдуулан шинээр 65 нас хүрсэн 10 ахмад настны мэдээллийг прораммд бүртгэсэн.

Ахмадын зориулалттай амралт сувилалын эрхийн бичгийг 4 ахмадад олгосон.

Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 7 иргэнд, асаргааны тэтгэмж сунгалт-2 иргэнд, 2620044 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

06-р сард Нийгмийн халамжийн ehalamj системид Нийгмийн халамжийн тэтгэвэрийн сунгалт 7 иргэн, асаргааны тэтгэмж 2 иргэнд, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 7 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 5 иргэнд, нийт 21 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид хамруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 57 хүний 3893400 төгрөг , сайн дурын даатгалд 23 хүний 2368350 төгрөгийн орлого орсон. 6 дугаар сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 413 хүнд 202132221 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0 төгрөг олгосон. Шинээр 3 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, 2 иргэний тэтгэвэр тогтоогдож, 1 иргэний тэтгэврийн материал хянагдаж байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: ЕБС: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Хүүхэд бүр бэлэгтэй баяр” уриан дор аймаг, улсын олимпиад уралдаан тэмцээнд амжилт гаргасан сурагчдыг сумын ЗДТГазар, ИТХ-ын хүндэт өргөмжлөл, бэлгээр шагнууллаа. Энэхүү арга хэмжээнд нийт 32 хүүхэд хамрагдлаа.

2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагаагаа нэгтгэн дүгнэх тайлагнах зорилгоор “Бүгдээрээ ярилцъя-Хамтдаа хөгжье” тайлант хэлэлцүүлгийг ЕБС-ийн багш нар, сургуулийн удирдлагын хүрээнд хийж энэ хичээлийн жилийн ололт амжилт, дараа хичээлийн жилд юун дээрээ анхаарах талаар “Сургалт, Манлайлал, Харилцаа, Хөгжил, Оролцоо” гэсэн сэдвийн хүрээнд бүлгээр ажиллаж асуудлаа тодорхойлон ярилцлаа.

Монгол улсын Гавьяат багш, олон улсын хэмжээний мастер, волейболын дасгалжуулагч н.Халзан сумын сурагчид болон иргэдэд волейболын сургалтыг 14 хоног зохион байгууллаа. Энэхүү сургалтанд ЕБСургуулийн 50 гаруй сурагчид хамрагдаж волейболын спортын анхан шатны мэдлэгтэй боллоо.

Сургуулийн 9,12-р ангийн суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсний баяр “Гэрчилгээ гардуулах ёслол” боллоо. Сурлагын амжилт гаргаж аймгийн төрөлжсөн олимпиадад 1,2,3-р байр эзэлсэн 4 суралцагчийг Монголын хүүхдийн ордны “Эрдэм” алт, мөнгөн медалиар шагналаа.

Улсын шалгалтын комисс БСШУС-ын А/425р тушаалын дагуу анги дэвших болон улсын шалгалтуудыг амжилттай зохион байгууллаа. 2021-2022 оны хичээлийн жилд тавдугаар ангийн 74 суралцагч математик, монгол хэл, хүн байгаль хичээлээр улсын шалгалт өгч математик 74%, монголхэл 81%, хүн байгаль 78.5%-ийн гүйцэтгэлтэй шалгагдав. Гурав, дөрөвдүгээр ангийн 194 суралцагч анги дэвших шалгалтыг математик, хүн орчин, хүн байгалийн хичээлээр нэгдмэл шалгалтыг 83.6%, дөрөвдүгээр ангийн 60 суралцагч монгол хэлний хичээлийн анги дэвших шалгалтыг 80.7%-ийн гүйцэтгэлтэй шалгагдав.

Ирэх хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх 6 настай 86 хүүхдийн судалгааг БШУГ-т иргэний бүртгэл ,хүн ам зүйн мэргэжилтэн, СӨБ-ийн арга зүйчтэй хамтран гаргаж хугацаанд нь явуулсан.

Улсын шалгалтыг есдүгээр ангийн 50 сурагч 5 хичээл судлагдахуунаар, арванхоёрдугаар ангийн 26 сурагч 6 хичээл судлагдахуунаар шалгалт өглөө. Улсын шалгалтад есдүгээр анги: Монгол хэл-79,5%, Математик-79%, Нийгэм судлал -82%, Байгалийн ухаан-81,5%, Англи хэл-75%, Орос хэл -82%, арванхоёрдугаар анги: Монгол хэл -87%, Математик-82%, Англи хэл-80%, Нийгмийн ухаан-95%, Биологи -90%, Газарзүй-100%, Физик-93% тус тус шалгагдлаа.

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ: Байгууллагын 4х8м харьцаатай хүлэмжид 50 ширхэг өргөст хэмх, 30 ширхэг улаан лоолийн суулгац суулгалаа.

5 жил тасралтгүй хөдөө орон нутагт ажилласан багшийн тэтгэмжид багш, тэтгэвэрт гарах 1 багшийн материалыг бүрдүүлж няглан бодогчид хүлээлгэн өглөө. 2021-2022 оны зорилтын тайланг чиглэл бүрээр гаргаж БШУГ-т хүргүүллээ.

2022-2023 оны хичээлийн жилд сургуульд элсэх хүүхдийн судалгаа, 2022-2023 онд ажиллах багш ажилтны судалгаа, дутагдалтай багшийн судалгаа, мэдээлэл харилцаа технологийн дэд бүтэц интернэт сүлжээний талаархи судалгаа, камержуулалтын судалгаа, санал гомдлын тоон мэдээ, СӨБ-д нийлүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүн тоглоомын судалгаа, эрт илрүүлэг үзлэгийн судалгаа зэрэг хугацаат тоон, болон тайлан мэдээнүүдийг хугацаа алдалгүй зохих газарт хүргүүлж байна.

Эхний жилдээ ажиллаж буй багшийн үндсэн сургалт хичээллэж 1 багш цахимаар хамрагдаж байна.

Зуны амралт эхэлсэнтэй холбоотой байгууллагын аюулгүй байдлыг хангах, гадна дотор эрсдэлээс сэргийлэх мөн гадна доторхи ногоон байгууламжийг услах тордох хамгаалах 2 манаач сахиул, эрхлэгч, нярав гэсэн бүрэлдэхүүн ажиллаж байна.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Үндэсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн суманд 5 дугаар сарын зохион байгуулагдлаа. Тэмцээнийг аймгийн сурын холбоо, аймгийн БТСГазар, сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 8 сумын 60 гаран харваач оролцлоо.

Тус сумын Соёлын төвийн дарга Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “ТАЛЫН МОНГОЛ” хүндэтгэлийн тоглолтонд оролцож, Соёлын Яамнаас зохион байгуулсан “Шинэ сэргэлтийн бодлого” хэлэлцүүлэгт оролцлоо.

Соёлын төвийн дэргэдэх “Шидэт Бийр” дугуйлангийн сурагчдын гар зургийн үзэсгэлэн зохион байгуулагдаж, дугуйланд хамрагдсан 20 гаруй хүүхдийн 120 орчим зураг дэлгэгдсэн.

Номын сан нь 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу гэрээр ном олголт хийх, нутгийн зохиолч яруу найрагчдын намтар, уран бүтээлийг сурталчлах, үйлчилгээний тоо хүрээг нэмэгдүүлэх зорилгоор фондны 2000 гаруй номтой үйл ажиллагаа тогтмол явуулж байна. LiB4U шинэчилсэн программд фондын номыг 100% шивж, тооллогод хамрууллаа.

Соёлын өвийн талаарх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, Соёлын өвийн тухай хуулийг цувралаар танилцуулж байна.

Соёлын төвийн дэргэд үндэсний морин хуурын дугуйланг 4-н сурагчидтай хичээллэж байна. Баяр наадмын нээлт соёлын үйл ажиллагааны бэлтгэлд ардын авьяастнуудыг хамруулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. 6 дугаар сарын байдлаар амбулаторийн нийт үзлэг 450, алсын дуудлага 12, гэрийн дуудлага 3, хэвтэн эмчлүүлэгч 18.

Ковидын вакцинжуулалт 6-р сард хамрагдсан хүн байхгүй. Энэ сард товлолын вакциныг 47 хүүхдэд хийгээд байна.

Гепатитгүй монгол төслийн хүрээнд Ротари клубын төсөл хэрэгжиж Улаанбаатар хотоос 5 хүний бүрэлдэхүүнтэй нарийн мэргэжлийн эмч нар ирж суманд 2 хоног ажиллан дүр оношилгоо-202, дотор-137, элэгний хатууралын оношилгоо-96, цусны шинжилгээ-130 хүнийг хамруулан В вирустэй-29, С вирустэй-3, Элэгний хавдартай-1 хүнийг илрүүлэн дараагийн шатлалд илгээсэн.

6 сард эх барих эмэгтэйчүүдийн үзлэгт 51 хүн хамрагдаж, зөвөлгөө зөвлөмжийг хүргэж ажиллсан байна.

Тухайн сард Лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 9, урлоги – 1, Шээс – 15, Ковид -1, Биохими -1, Элгэний В, С вирусын илрүүлгийн шинжилгээнд 44 хүн тус тус хамруулаад байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг